



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймаг Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2021/92/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Дорноговь аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: [Oyuntulkuur.u@audit.gov.mn](mailto:Oyuntulkuur.u@audit.gov.mn)

Аудитор:

Б.Уранбилэг

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ХАТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Т.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

2021.02.25 № 16/247  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2020020276

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,732,517.68</b>	<b>81,254,232.28</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	177,900.82	2,345,561.13
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	177,900.82	2,345,561.13
3351	Байгууллагаас авах авлага	177,900.82	2,094,761.13
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	250,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	78,554,616.86	78,908,671.15
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	34,403,060.12	47,050,799.41
35110	Тусгай зориулалттай материал	34,403,060.12	47,050,799.41
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	17,861,356.74	5,419,671.74
35410	Бичиг хэргийн материал	4,933,440.00	3,813,360.00
35420	Аж ахуйн материал	1,216,815.00	1,606,310.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,965,100.00	-
35440	Түлш, шатах тослох материал	5,746,001.74	1.74
35600	Мал амьтад	26,290,200.00	26,438,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,069,856,416.92</b>	<b>2,514,279,277.11</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,069,856,416.92	2,514,279,277.11
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,922,972,416.92	2,365,359,152.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,110,705,444.70	1,362,805,444.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,748,067.27)	(75,833,517.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	217,873,800.00	305,593,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,842,220.77)	(143,322,420.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,849,722.29	162,718,942.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,588,635.23)	(84,469,047.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,753,645.69	72,543,645.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,046,382.95)	(32,361,865.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,596,540,853.30	1,842,330,394.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(939,470,742.84)	(1,055,591,224.68)
39217	Ном	10,945,000.00	10,945,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	146,884,000.00	148,920,125.03
39301	Програм хангамж	1,784,000.00	4,290,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,784,000.00)	(2,253,874.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	146,884,000.00	146,884,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,148,588,934.60</b>	<b>2,595,533,509.39</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>90.00</b>	<b>431,540.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	90.00	431,540.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	90.00	431,540.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	90.00	431,540.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	431,450.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	90.00	90.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,148,588,844.60</b>	<b>2,595,101,969.39</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,148,588,844.60	2,595,101,969.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,514,989,636.59	1,514,989,636.59
51101	Өмч: - төрийн	1,514,989,636.59	1,514,989,636.59
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	466,552,428.86	913,065,553.65
51210	Өмнөх үеийн үр дүн	466,552,428.86	466,552,428.86
51220	Тайлант үеийн үр дүн	-	446,513,124.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,046,779.15	167,046,779.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,148,588,934.60</b>	<b>2,595,533,509.39</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,161,231,094.70</b>	<b>1,269,072,476.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>602,898,700.00</b>	<b>628,902,157.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	602,898,700.00	628,902,157.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	602,898,700.00	5,660,796.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,177,700.00	5,660,796.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	596,721,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө		605,374,761.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал		17,866,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>558,332,394.70</b>	<b>640,170,319.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	161,096,994.70	177,948,005.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,500,000.00	148,509,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	144,596,994.70	29,438,405.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	397,235,400.00	462,222,314.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,235,400.00	462,222,314.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>714,402,541.96</b>	<b>822,559,351.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>714,402,541.96</b>	<b>822,559,351.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	708,984,100.54	819,613,417.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	232,191,674.30	279,182,382.92
210101	Үндсэн цалин	232,191,674.30	278,962,382.92
210104	Урамшуулал	-	220,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,939,020.61	35,498,084.35
210201	Тэтгэврийн даатгал	20,399,062.42	24,657,099.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,390,313.00	2,934,107.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,904,573.50	1,826,834.94
210204	Ажилгүйдлийн даатгал	476,142.00	518,961.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,768,929.69	5,561,081.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,520,902.98	24,099,315.00
210301	Гэрэл, цахилгаан	2,200,457.98	4,068,791.00
210302	Түлш, халаалт	11,320,445.00	19,547,092.00
210303	Цэвэр, бохир ус	-	483,432.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,427,455.00	39,334,922.38
210401	Бичиг хэрэг	5,851,580.00	7,716,080.00
210402	Тээвэр, шатахуун	30,181,255.00	27,231,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,536,440.00	3,240,387.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	738,180.00	1,027,005.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	330,000.00
210502	Хоол, хүнс	-	330,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,212,300.00	5,965,100.00
210604	Урсгал засвар	6,212,300.00	5,965,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,905,400.00	4,827,500.00
210702	Дотоод албан томилолт	4,905,400.00	4,827,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	145,880,418.00	203,427,611.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,363,533.00	200,431,794.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	1,410,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	552,800.00	363,870.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	269,907.00	765,901.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,178.00	198,000.00
210807	Газрын төлбөр	278,000.00	258,046.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	232,906,929.65	226,948,500.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,713,774.70	22,596,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	186,451,154.95	204,351,900.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,418,441.42	2,945,934.54
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,830,000.00	1,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,530,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,588,441.42	1,445,934.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,588,441.42	1,445,934.54

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>446,828,552.74</b>	<b>446,513,124.79</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,242,477.57	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,242,477.57	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,242,477.57)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>440,586,075.17</b>	<b>446,513,124.79</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>565,039,154.83</b>	<b>645,949,243.63</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,177,700.00</b>	<b>5,660,796.50</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,177,700.00	5,660,796.50
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	6,177,700.00	5,660,796.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,177,700.00	5,660,796.50
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>558,861,454.83</b>	<b>640,288,447.13</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	161,626,054.83	178,066,133.13
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,500,000.00	148,509,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,126,054.83	29,556,533.13
131106	Төсвийн урамшуулал		
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	397,235,400.00	462,222,314.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,235,400.00	462,222,314.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>538,628,087.83</b>	<b>600,462,732.50</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>538,628,087.83</b>	<b>600,462,732.50</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>533,091,518.28</b>	<b>597,516,797.96</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	232,248,399.40	278,964,210.23
210101	Үндсэн цалин	232,248,399.40	269,389,128.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,355,081.90
210104	Урамшуулал	-	220,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,825,517.20	35,498,084.35
210201	Тэтгэврийн даатгал	20,251,400.00	24,657,099.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,376,148.50	2,934,107.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,500.00	1,826,834.94
210204	Ажилгүйдлийн даатгал	469,068.70	518,961.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,799,400.00	5,561,081.84
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,774,957.98	20,609,315.00
210301	Гэрэл, цахилгаан	2,200,457.98	5,129,791.00
210302	Түлш, халаалт	10,574,500.00	14,996,092.00
210303	Цэвэр, бохир ус	-	483,432.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	46,328,840.00	37,476,387.38
210401	Бичиг хэрэг	5,459,200.00	6,585,050.00
210402	Тээвэр, шатахуун	30,993,200.00	26,231,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,536,440.00	3,540,387.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,220,000.00	999,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	800,000.00	2,528,000.00
210502	Хоол, хүнс	-	330,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	2,198,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,699,100.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	360,000.00	-
210604	Урсгал засвар	9,339,100.00	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	4,905,400.00	4,827,500.00
210702	Дотоод албан томилолт	4,905,400.00	4,827,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	157,080,529.00	190,103,301.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,563,644.00	187,107,484.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	1,410,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	532,800.00	363,870.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	289,907.00	765,901.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,178.00	198,000.00
210807	Газрын төлбөр	278,000.00	258,046.00

**Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,428,774.70	27,510,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,928,774.70	26,010,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,536,569.55</b>	<b>2,945,934.54</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,830,000.00</b>	<b>1,500,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,530,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,706,569.55</b>	<b>1,445,934.54</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,706,569.55	1,445,934.54
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		2,086,511.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>26,411,067.00</b>	<b>43,400,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>43,400,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>43,400,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>43,400,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	-	43,400,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>≡</b>	<b>(43,400,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>26,411,067.00</b>	

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,514,989,636.59	167,291,954.08	15,867,754.76	1,698,149,345.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	12,898,965.93	12,898,965.93
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,514,989,636.59</b>	<b>167,291,954.08</b>	<b>28,766,720.69</b>	1,711,048,311.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(245,174.93)	-	(245,174.93)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	440,586,075.17	440,586,075.17
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,514,989,636.59</b>	<b>167,046,779.15</b>	<b>469,352,795.86</b>	2,151,389,211.60
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,514,989,636.59</b>	<b>167,046,779.15</b>	<b>469,352,795.86</b>	2,151,389,211.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,514,989,636.59</b>	<b>167,046,779.15</b>	<b>469,352,795.86</b>	2,151,389,211.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	446,513,124.79	446,513,124.79
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,514,989,636.59</b>	<b>167,046,779.15</b>	<b>915,865,920.65</b>	2,597,902,336.39

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	468,195,200.00	466,437,175.96	1,758,024.04	100%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	468,195,200.00	466,437,175.96	1,758,024.04	100%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	466,695,200.00	464,937,175.96	1,758,024.04	100%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	279,189,100.00	278,744,210.23	444,889.77	100%
210101	Үндсэн цалин	270,889,100.00	269,389,128.33	1,499,971.67	99%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,300,000.00	9,355,081.90	(1,055,081.90)	113%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,942,200.00	35,498,084.35	444,115.65	99%
210201	Тэтгэврийн даатгал	24,657,100.00	24,657,099.57	0.43	100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,765,100.00	2,934,107.00	(169,007.00)	106%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,213,700.00	1,826,834.94	386,865.06	83%
210204	Ажилгүйдлийн даатгал	572,000.00	518,961.00	53,039.00	91%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,734,300.00	5,561,081.84	173,218.16	97%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,658,800.00	20,609,315.00	49,485.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	5,135,400.00	5,129,791.00	5,609.00	100%
210302	Түлш, халаалт	15,000,700.00	14,996,092.00	4,608.00	100%
210303	Цэвэр, бохир ус	522,700.00	483,432.00	39,268.00	92%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,620,300.00	35,607,749.38	12,550.62	100%
210401	Бичиг хэрэг	6,200,000.00	6,200,050.00	450.00	100%
210402	Тээвэр, шатахуун	25,075,800.00	25,073,812.00	1,988.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,224,000.00	3,214,387.38	9,612.62	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	999,500.00	500.00	100%
2105	<b>Нормативт зардал</b>	2,200,000.00	2,198,000.00	2,000.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,200,000.00	2,198,000.00	2,000.00	100%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,524,000.00	26,300,000.00	224,000.00	99%
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,024,000.00	17,800,000.00	224,000.00	99%
210604	Урсгал засвар	8,500,000.00	8,500,000.00	-	100%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3,742,800.00	3,667,500.00	75,300.00	98%
210702	Дотоод албан томилолт	3,742,800.00	3,667,500.00	75,300.00	98%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	56,318,000.00	55,812,317.00	505,683.00	99%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,900,000.00	52,816,500.00	83,500.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,600,000.00	1,410,000.00	190,000.00	88%
210803	Даатгалын үйлчилгээ	390,000.00	363,870.00	26,130.00	93%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	780,000.00	765,901.00	14,099.00	98%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	218,000.00	198,000.00	20,000.00	91%
210807	Газрын төлбөр	430,000.00	258,046.00	171,954.00	60%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,500,000.00	6,500,000.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00	-	100%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,500,000.00	1,500,000.00	-	100%
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,500,000.00	1,500,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	468,195,200.00	467,883,110.50	312,089.50	100%
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	461,195,200.00	462,222,314.00	(1,027,114.00)	100%
132001	Орон нутгийн төсвөөс	461,195,200.00	462,222,314.00	(1,027,114.00)	100%
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	7,000,000.00	5,660,796.50	1,339,203.50	81%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	5,660,796.50	1,339,203.50	81%
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100%
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30.00	26.00	4.00	87%
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	12.00	1.00	92%
620003	Үйлчлэх ажилтан	7.00	4.00	3.00	57%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>175,979,622.00</b>	<b>(175,979,622.00)</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	175,979,622.00	<b>(175,979,622.00)</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	175,979,622.00	<b>(175,979,622.00)</b>
210101	Үндсэн цалин	-	220,000.00	<b>(220,000.00)</b>
210105	Гэрээт ажлын хөлс	-	220,000.00	<b>(220,000.00)</b>
210401	Бичиг хэрэг	-	1,868,638.00	<b>(1,868,638.00)</b>
210402	Тээвэр, шатахуун	-	385,000.00	<b>(385,000.00)</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,157,638.00	<b>(1,157,638.00)</b>
210404	Ном, хэвлэл	-	326,000.00	<b>(326,000.00)</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	330,000.00	<b>(330,000.00)</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	330,000.00	<b>(330,000.00)</b>
210701	Гадаад албан томилолт	-	1,160,000.00	<b>(1,160,000.00)</b>
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	1,160,000.00	<b>(1,160,000.00)</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	151,390,984.00	<b>(151,390,984.00)</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	151,390,984.00	<b>(151,390,984.00)</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	21,010,000.00	<b>(21,010,000.00)</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	21,010,000.00	<b>(21,010,000.00)</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	178,066,133.13	<b>(178,066,133.13)</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	178,066,133.13	<b>(178,066,133.13)</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	148,509,600.00	<b>(148,509,600.00)</b>
131106	Төсвийн урамшуулал	-	29,556,533.13	<b>(29,556,533.13)</b>

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Цэцэгсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 22–ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 21-ний өдрийн 05/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 2020 оныг “Хөрөнгө оруулалтыг дэмжих жил” болгон тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 822,237.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,222.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 446,821.9 мянган төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	177.9	2,345.6	2,167.7
Урьдчилгаа			-
Бараа материал	78,554.6	78,908.7	354.1
Үндсэн хөрөнгө	2,069,856.4	2,514,279.3	444,422.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,148,588.9</b>	<b>2,595,533.5</b>	<b>446,944.6</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,148,588.9	2,595,533.5	446,944.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,148,588.9</b>	<b>2,595,533.5</b>	<b>446,944.6</b>

Авлага дансны үлдэгдэл 2,345.6 мянган төгрөг болж 2,167.7 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасанатай холбоотой байна. Мөн байрны түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйгээс 250.8 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,908.7 мянган төгрөг болж 354.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотойгоор халдвар хамгааллын хэрэгслийн нөөц бүрдүүлсэн шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,514,279.3 мянган төгрөг болж 444,422.9 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвөөс 43,400.0 мянган төгрөгийн худалдан авалт хийгдсэн, хандиваар болон үнэ төлбөргүйгээр 605,374.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирснээр тус тус нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгөнд хасагдсан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 431.5 мянган төгрөг болж 431.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь түрээсийн орлогын 50 хувийг орон нутгийн өмчийн дансанд буцаан төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,595,533.5 мянган төгрөг болж 446,944.6 мянган төгрөгөөр өссөн нь байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 107,841.4 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого зэрэгт материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 108,156.8 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, байр ашигласантай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бусад урсгал шилжүүлэг зардлууд байна. Энэ нь батлагдсан төсөв, төлөвлөгөө мөн тайлант онд үүссэн халдварт өвчин зэрэг нь нөлөөлсөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 514,750.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 514,750.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 46,555.6 мянган төгрөгөөр бууруулж 468,195.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 468,195.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 467,883.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 462,222.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,660.8 мянган төгрөг, нийт 467,883.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 466,437.2 мянган төгрөгийг зарцуулж 1,445.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466,437.2 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын зардлыг 444.1 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засвар зардлыг 224.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 505.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоор 7,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,660.8 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 80.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,000.0	5,660.8	1,339.2	80.87
<b>Нийт дүн</b>	<b>7,000.0</b>	<b>5,660.8</b>	<b>1,339.2</b>	<b>80.87</b>

Туслах үйл ажиллагааны орлогыг байрны түрээс болон түүхий эд худалдан борлуулснаар бүрдүүлдэг боловч тайлант онд цар тахалтай холбоотойгоор сургууль, цэцэрлэг ажиллаагүйгээс сумын төвд байрлах байрыг түрээслүүлэх нөхцөл бүрдээгүй улмаас төлөвлөсөн орлого тасарсан байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 148,509.8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29,556.5 мянга, нийт 178,066.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 1,868.6 мянга, хоол хүнсний зардалд 330.0 мянга, урамшуулал зардалд 220.0 мянган төгрөгийг, дотоод албан томилот зардалд 1,160.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 151,391.0 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 21,010.0 нийт 175,759.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,086.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	2		2				
Зөвлөмж	3		3				
Нийт дүн	5		5				

/мянган төгрөг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,679.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,657.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 628.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,339.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлжээ

## **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 701.3 мянган төгрөгийн шатахууныг бараа материалд орлого авалгүй шууд зардалд бичсэнийг залруулав
2. 512.0 мянган төгрөгийн гэр интернэт цэнэглэлтийг бичиг хэргийн дансаар дамжуулж зардал бичсэнийг залруулав.
3. 444.6 мянган төгрөгийн ноолуурыг бараа материал дансанд бүртгэлгүй шууд худалдан борлуулсны орлогыг төвлөрүүлснийг залруулав.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 2,021.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 628.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант нийт төвлөрүүлэх түрээсийн орлогоос 2 иргэн 250.8 мянган төгрөгийн орон сууц түрээсэлсний төлбөрөө төлөөгүй байна. Энэ нь Хатанбулаг сумын ЗДТГ-ын газрын даргын 2020 онд байгуулсан 13, 24 дугаар гэрээ, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын “Орон нутгийн өмчийн орон сууцны түрээсийн гэрээ”-ний 2 дугаар хавсралтын 5 дахь хэсэгт заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант онд байр түрээслүүлсний орлого нийт 9,569,5 мянган төгрөгийг бүрдүүлсэн боловч 4,353.3 мянган төгрөгийг орон өмчийн дансанд шилжүүлж 431.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байна. Энэ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 3.10-т “Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг сар бүр аймгийн түрээсийн орлогын дансанд төвлөрүүлнэ, ....” гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн зөрчилд 1,339.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудалд байхгүй байна.

#### 4. Менежментийн захидал

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой:*

- 1.1. Илрүүлэлт Тайлант онд 7,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 5,660.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 11.2 хувиар буюу 1,339.2 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба Төсвийн тухай хуулийн 6.2.2-т жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.
- 1.2. Эрсдэл: Орлогын төлөвлөгөө тасарч төлөвлөсөн зардал хүрэлцэхгүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Тайлант онд төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлэх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГазрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			САГ-ДГА-2021/92/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГазар</i>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууныг бараа материалд орлого авахгүй шууд зардалд бүртгэсэн	701.3	Аудитын явцад залруулав	Дарга. Нягтлан бодогч	Т.Цэцэгсүрэн Б.Чаминчулуу
2	Зардлыг зөрүүтэй тайлагнасан буюу шуудан холбооны зардлыг бичиг хэргийн зардалд бүртгэсэн	512.0	Аудитын явцад залруулав	Дарга. Нягтлан бодогч	Т.Цэцэгсүрэн Б.Чаминчулуу
3	Ноолуур борлуулсны орлого болох 444.6 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн боловч ноолуурыг бараа материалын дансанд бүртгээгүй байна.	444.6	Аудитын явцад залруулав	Дарга. Нягтлан бодогч	Т.Цэцэгсүрэн Б.Чаминчулуу
4	Тайлант нийт төвлөрүүлэх түрээсийн орлогоос 2 иргэн 250.8 мянган төгрөгийн орон сууц түрээсэлсний төлбөрөө төлөөгүй байна.	250.8	Төлбөрийн акт тогтоох	Дарга. Нягтлан бодогч	Т.Цэцэгсүрэн Б.Чаминчулуу
5	Тайлант онд байр түрээслүүлсний орлого нийт 9,569,5 мянган төгрөгийг бүрдүүлсэн боловч 4,353.3 мянган төгрөгийг орон өмчийн дансанд шилжүүлж 431.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.	431.5	Төлбөрийн акт тогтоох	Дарга. Нягтлан бодогч	Т.Цэцэгсүрэн Б.Чаминчулуу
6	Тайлант онд 7,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 5,660.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь 11.2 хувиар тасарсан байна.	1,339.2	Зөвлөмж өгөх	Дарга. Нягтлан бодогч	Т.Цэцэгсүрэн Б.Чаминчулуу
<b>ДҮН</b>		<b>3,679.4</b>			